




Оксфордын
уншлагын
мог

БАГШИЙН НОМ

Шатлал 2
Үлгэрүүд



Родерик Хант
Алекс Бричта

Багшийн ном

Өмнөх үг 2

Үгсийн сангийн хүснэгт 4



Флопиг угасан нь

Уншлага 5
Ярих болон сонсох үйл ажиллагаа 7
Бичих үйл ажиллагаа 7



Хүүхэд асрагч

Уншлага 8
Ярих болон сонсох үйл ажиллагаа 10
Бичих үйл ажиллагаа 10



Усаар байлдсан нь

Уншлага 11
Ярих болон сонсох үйл ажиллагаа 13
Бичих үйл ажиллагаа 13



Кипперийн бөмбөлөг

Уншлага 14
Ярих болон сонсох үйл ажиллагаа 16
Бичих үйл ажиллагаа 16



Кипперийн төрсөн өдөр

Уншлага 17
Ярих болон сонсох үйл ажиллагаа 18
Бичих үйл ажиллагаа 19

Өмнөх үг

Шатлал 1-д танил болсон зохиолын дүр, үйл явдлын орчин нөхцөлд шатлал 2-ын үлгэрүүд өрнөж буйгаар харуулсан нь хүүхдүүдэд дотно танил болж байгаа юм. Ихэнхи 4-6 насны хүүхдэд тохиолддог төрсөн өдөр тэмдэглэх, харуулдаг хүнтэй болох зэрэг тохиолдлуудыг тусгасан юм. Энэ насны хүүхдүүд зохиолын дүр болон орчинд алив юмыг дуртайяа танин мэдэж авдаг.

Үлгэрийн ном бүхэнд бүрэн үлгэрийг өгүүлэх бөгөөд зохиолын учиг дарааллыг хүүхдүүдэд ойлгуулахын тулд зураг, бичиглэл нь хамтдаа байснаар жирийн өгүүлбэрийн утгыг таахад тэдэнд туслах хэрэгтэй юм. Энэхүү үлгэрүүд нь хүүхдүүдийг хуудсан дахь танил бус эхийг уншихдаа бүх хэрэгтэй дараалалыг хэрэглэхэд урамшуулдаг байна. Энэ аргаар хүүхдийг уншиж чаддаг болоход хэрэгтэй өргөн хүрээний бүх чадваруудыг хөгжүүлдэг ажээ. Үлгэрүүдийг урьдаас таамаглаж болохуйц хэв маягтай жинхэнэ ярианы хэлээр бичсэн байна.

Энэхүү номнуудыг хэрхэн танилцуулах вэ?

Биеэ дааж буюу бусдаар хөтлүүлж энэхүү үлгэрийг уншихын өмнө ямагт номын хавтсыг хүүхдүүдэд харуулж, үлгэрийн тухай өгч буй мэдээллийг ярилц. Номоор хамтдаа аялж, зурагнуудыг үзэж, түүний тухай ярилц. Хэрэв танил бус буюу шинэ үгс байвал үгстэй хамт байгаа зургаас заа (энэ товхимлын 4-р хуудсан дээр жагсаасан үг)

Энэ товхимол нь биеэ даасан болон бүлгээр үйл ажиллагаа явуулах үед номыг хэрэглэх зөвлөгөө өгдөг. Танилцуулж буй санамж болон санаанууд нь ном тус бүрийг нэг буюу бүлэг хүүхдүүд уншихад зориулагдсан. Үйл ажиллагаанууд нь хүүхдэд хам сэдвийн дараалал, зургийн дараалал, хэл зүйн дараалал, үг нүдлэх болон авиа зүйн дараалал зэргийг багтаан, унших чадварын шатлалыг хөгжүүлэхэд тусалдаг юм. Ярих сонсох үйл ажиллагаа болон бичих үйл ажиллагаа, хичээл хоорондын уялдааны талаар зөвлөгөө өгдөг.

Мөн шатлал бүр дэх зургаан гарчигт зориулсан тусдаа хөтлөн унших карт бий. Ном бүрт «гэрийн карт» хэрэгтэй. Энэ нь хүүхдүүдтэйгээ хамт унших эцэг эхчүүдэд нөхөрсөг санамж зөвлөгөөг өгдөг ажээ. Та холбогдох картыг номтойгоо хамт гэртээ авч явж, цуглуулагдаа хадгалж болно.

Унших чадвар

- Шатлал 2-ыг уншсанаар:
- Номтой зөв харьцах болон эхийн шууд утгыг ойлгох
- Эхийг ойлгох арга барилд сурах
- Зураг болон эхийн холбоо, авиа зүйн ойлголтыг олж авах
- Жишээлбэл, авиаг үсгээр тэмдэглэдэг юм гэсэн ойлголт
- Эрт бичиж сурах чадваруудыг хөгжүүлнэ.

Үгсийн сангийн хүснэгт

Флоппиг угаасан нь	Олон давтагдах үгс	аав, нохой, харсан, ээж, тэд, явав
	Эхэд хамаатай үгс	усны онгоц, Биф, хөөв, Чип, цэвэрхэн, хашаа, Флоппи, гэр, Киппер, шавартай, туулай, харсан, угаасан, нойтон
Хүүхэд асрагч	Олон давтагдах үгс	аав, явах, тэр, ээж, үгүй, хэлсэн, тэд, байсан, бид, тийм
	Эхэд хамаатай үгс	хүүхэд асрагч, ор, Биф, ном, ирсэн, Чип, доод давхар, байлдах, түүний, өлсөх, Киппер, хийв, хачиртай талх, унтах, үлгэр, хүссэн
Усаар байлдсан нь	Олон давтагдах үгс	аав, дотор, ээж, үгүй, хэлсэн
	Эхэд хамаатай үгс	Биф, хувин, элдэж хөөсөн, хүүхдүүд, Чип, дүүргэсэн, байлдах, халуун, Киппер, түлхсэн, сэлэх, цацсан, хүссэн, ус
Кипперийн бөмбөлөг	Олон давтагдах үгс	нэгэн, болон, аав, тэр, энэ, ээж, үгүй, хэлсэн, байсан, явсан
	Эхэд хамаатай үгс	хойноос, цааш, бөмбөлөг, хийссээр, худалдаж авсан, элдэж хөөсөн, Киппер, шинэ, гүйв, харсан, дэлгүүр, хөшөө, супер маркет, жорлон
Кипперийн төрсөн өдөр	Олон давтагдах үгс	ирэх, аав, ээж, авах, хэлэх, тоглох, хэлсэн, байсан
	Эхэд хамаатай үгс	бөмбөлгүүд, Биф, төрсөн өдөр, бялуу, ирсэн, хүүхдүүд, хүн бүр, тоглоом, Киппер, хийсэн, үдэшлэг, хачиртай талх, зурагт, хүссэн



Флоппиг угаасан нь

Уншихын өмнө

- Гарчгийг уншуулж, хавтсан дээрх зургийг үзүүлээд, яагаад Флоппиг угаах хэрэгтэй болов оо? гэж хүүхдүүдээс асуу.
- Үлгэрийг гүйлгэн хараад, Флоппи хаашаа явж шавартай хутгалдаж, юу хийсэн бэ?
Гэр бүлийнхэн нь Флоппид зориулж юу хийсэн бэ?
Үлгэрийн төгсгөлд Флоппи юу хийсэн бэ? гэж асуу.

Унших үед

- Үлгэрийг хүүхдүүдээр чанга уншуулахдаа магтаж урамшуул, шаардлагатай үед нь сануулан хэлж өг.
- Мэдэхгүй үгээ нүдэлж байхдаа хүүхдүүд зураг болон эхний үсгийг хараад юу ойлгохыг нь бодож олоход нь урамшуул.

Ажиглалт

- Хүүхдүүдийнхээ мэдэхгүй үгээ нүдлэхэд нь цагаан толгойн болон хэл ярианы мэдлэгийг нь шалга.
- Зүүнээс баруун тийш түгдрэлгүй уншуул.
- Номын өгүүлэмжийг зөв хэрэглүүл.
- Эх хоорондын уялдааг зөв хэрэглэж байгааг шалга.

Бүлгээр болон бие даан унших үйл ажиллагаа

Эхийн төвшинд ажиллах

Зорилт Үлгэрийн бүтэц, өрнөж төгсөж буй аргыг ухаарах.

- Асуулт: Үлгэрийн эхэнд Флоппи юу харсан бэ?
Үлгэрийн дунд үед Флоппид юу тохиолдсон бэ?
Үлгэрийн төгсгөлд Флоппи юу харсан бэ?
Үлгэрт дараа нь юу тохиолдоно гэж чи бодож байна вэ?

Ажиглалт

Хүүхдүүд үлгэрийн төгсгөл хаана байна, мөн үйл явдал давтагдаж байгааг ойлгож байна уу?

Өгүүлбэрийн төвшинд ажиллах

Зорилт

Ойлгож, ухаанаа шалгахын тулд бичсэн эхийг таамаглах Самбар дээр буруу бичигдсэн үйл үгтэй дараах өгүүлбэрүүд танд хэрэг болно.

Флоппи туулайг оруулсан.

Флоппи шавартай харсан.

Тэд Флоппийг усны онгоцонд болсон.

- Хүүхдүүдээр өгүүлбэрийг уншуулж, буруу өгүүлбэр дотроос ямар үг нүдэлснийг нь асуу. Тэднийг бодож олоход нь сануулах үг асуу. Хэрэв тэд зөв хийсэн бол шалгахдаа урамжуулж бай.

Ажиглалт

Хүүхдүүд бодож олсон үгээ санаж байна уу?

Цаашид хэрэглэх үйл үгнүүдийг санаж байна уу?

Үгийн төвшинд ажиллах

Зорилт

Ч,Ш,Т авиаг илэрхийлж буй үсэгнүүдийг унших.

Та самбар дээр дараах Ч, Ш, Т үсэгнүүдийг бичнэ.

- Хүүхдүүдээс эдгээр үсэгнүүдийг хэлэхэд ямар авиа гарч байгааг асуу. Эдгээр үсэгнүүд орсон үгийг тэд хэлж чадах уу? Хүүхдүүдийн хэлсэн үгийг самбар дээр жагсаан бич.
- Хүүхдүүдээр үлгэрийн номыг гүйлгэн харуулаад эдгээр үсэгнүүд орсон үгийг олуул. Жишээ нь: талх, шөнө, чимээ гэх мэт.

Ажиглалт

Хүүхдүүд үгэн дэх эдгээр үсэгнүүдийг таньж, ямар авиа гарч байгааг нь мэдэж байна уу?

Ярих болон сонсох үйл ажиллагаа

Зорилт Туршилтыг тодорхойлох, төлөвлөж, дүгнэлт гаргах.
Танд жижиг тарагны сав нэлээд хэдэн ширхэг хэрэг болох бөгөөд тус бүрд нь үнэр их ялгаруулдаг зүйлийг хийсэн байх хэрэгтэй. Жишээ нь: Кофе, шоколад, банаана, шарсан төмс, самар, бяслаг, лимон, жүрж гэх мэт. Савнуудыг цаасаар битүүлээд үнэр гаргах хэмжээний онгорхой гарга. Сав бүрийг дугаарла.

- Хэрхэн үнэрлэх мэдрэмжээ ашиглан Флоппи, туулайг хаана байгааг мэдэж чадсан талаар ярилц.(6 хуудас)
- Сав тус бүрийг хүүдүүдээр үнэрлүүлж юу үнэртэж байгааг асуу. Тэдний хариултыг самбар дээр бичээд хажууд нь дугаарыг нь тавь.
- Тэдний бодлыг харьцуулж ярилц.
- Сав тус бүрээс юу үнэртэж байгааг хэлж өг.

Амьдрал, хичээлийн уялдаа

◀▶ Ерөнцийн талаарх ойлголт: Тохирсон мэдрэмжүүдээ ашиглан юмс үзэгдлийг судлаарай.

Бичих үйл ажиллагаа

Зорилт Бичих үйл ажиллагааг хэд хэдэн төрлөөр турших.

- Хүүхдүүдэд хамгийн сайхан үнэртсэн зүйлийн талаар ярь. (Ярих сонсох үйл ажиллагааг хар)
- Самбар дээр «Би үнэрт дуртай» гэж бич. Хүүхдүүдийн хариултын эхний үсгийг онцолж бич.
- Хүүхдүүдээр үнэртэх дуртай хоёр зүйлийнх нь зургийг зуруулаад зураг тус бүрийнх нь доор «Би үнэрт дуртай» гэж бичүүлээрэй.
- Та хүүхдүүдийн хариултыг эмхтгэж ангийн номтой болж болно.



Хүүхэд асрагч

Уншихын өмнө

- Гарчгийг уншуулж хавтсан дээрх зургийг харуулаад, Хүүхэд асрагч гэж хэн бэ? Та нар харуулдаг хүнтэй байсан уу? гэж хүүхдүүдээс асуу.
- Хүүхэд асрагч хэрхэн хүүхдүүдийг асрамжилж байгааг номноос харуулаад, Яагаад хүүхдүүд доод давхарт бууж ирсэн бэ? Хүүхэд асрагч юу хийсэн бэ? гэж асуу.

Унших үед

- Хүүхдүүдээр үлгэрийг уншуул. Хүүхдүүдийг үлгэрийг уншиж байхад нь магтаж урамшуул, шаардлагатай бол сануулан хэлж өг.
- Мэдэхгүй үгээ нүдлэхэд нь зургийн дараалал, үсгийн дарааллыг хэрэглэхэд урамшуул.

Ажиглалт

Мэдэхгүй үгээ нүдлэхдээ цагаан толгойн болон хэл ярианы мэдлэгээ ашиглах.

- Номын өгүүлэмжийг зөв хэрэглэх.
- Эх хоорондын уялдааг зөв хэрэглэж байгааг шалгах

Бүлгээр болон бие даан унших үйл ажиллагаа

Эхийн төвшинд ажиллах

Зорилт Зөв дарааллаар гол утга санааг тоочиж сайн мэдэх сэдвээ бусдад ярьж өгөх.

- Асуулт: Яагаад хүүхдүүд доод давхарт бууж ирсэн бэ? Киппер юу хийхийг хүссэн бэ? Биф юу хийхийг хүссэн бэ? Тэднийг унтахад хүүхэд асрагч юу хийсэн бэ? Чип юу хийхийг хүссэн бэ? Аав ээж хоёр юу тохиолсоныг мэдсэн гэж бодож байна уу? Яагаад? эсвэл яагаад үгүй гэж?

Ажиглалт

Хүүхдүүд өөрийн үгээр үлгэрийг ярьж чадаж байна уу?
Тэд үлгэрийн өгүүлбэрийг хэрэглэж байна уу?

Өгүүлбэрийн төвшинд ажиллах

Зорилт Зүүнээс баруун тийш дараалсан үгийг ухан ойлгож уншуулах.

Самбар дээр дараах хэсэгчилсэн өгүүлбэрийг бичих хэрэгтэй. Түүний хажуугаар дутсан үгийг тусад нь бичээрэй.

Киппер авсан. (номнуудыг)

Тэд хийв. (хачиртай талх)

Чип байлдахыг хүссэн. (дэрээр)

Хүүхдүүдээр өгүүлбэрийг уншуулж, сүүлийн үгийг хаана тавихад өгүүлбэр зөв болж байгааг нүдлүүл.

Шаардлагатай бол тэднийг номоо хэрэглэхийг нь зөвшөөр.

Ажиглалт

Хүүхдүүд өөрсдийгөө шалгаж, өгүүлбэрийг ахин уншиж байна уу?

Үгийн төвшинд ажиллах

Зорилт Танил үгээ шууд унших. Жишээ нь: Хүүхдүүдийн нэрс гэх мэт.

Танд «Орондоо буцаж ор»

«Би үлгэр уншихыг хүсч байна».

«Би хачиртай талх идэхийг хүсч байна».

«Би дэрээр байлдахыг хүсч байна».

«Ямар заваан юм бэ?»

«Бүгдээрээ сайн байсан уу?»

«Тийм» эсвэл «Үгүй» гэж бичсэн өгүүлбэрийн картууд хэрэг болно.

- Эдгээр үгийг хэлсэн дүрүүдийн нэрийг хүүхдүүдээр хэлүүлж, нэрийг нь бичүүл.

Хүүхдүүд том үсэг ашиглан дүрүүдийн нэрийг бичиж чадаж байна уу?

Ярих болон сонсох үйл ажиллагаа

Зорилт Гол утга санаан дээр төвлөрөх, холбогдох тайлбар хийх, ярилцаж сангаага дэлгэрүүлэх, бүлгээр ярилцаж үзэл бодлоо илэрхийлэх.

- Хүүхдүүдээр хүүхэд асрагчийг сайн эсвэл муу хүүхэд асрагч уу? гэдгийг хэлэлцүүл. Хүүхдүүдийн дийлэнх нь юу гэж үзэж байгаа талаар санал ав.
- Биф, Чип болон Киппер нар түүнийг сайн хүүхэд асрагч гэж бодсон уу? Яагаад?
Аав ээж хоёр түүнийг сайн хүүхэд асрагч гэж бодсон уу? Яагаад? гэж асуу.

Бичих үйл ажиллагаа

Зорилт Янз бүрийн аргаар харилцахдаа бичих үйл ажиллагааг хэрэглэх.

- Хүүхдүүдийг ээлжээр унтахын өмнө юу хийдгийг нь дохиогоор илэрхийлүүл. Жишээ нь: Халуун юм уух, усанд орох, унтлагын хувцас өмсөх, шүдээ угаах, хайртай тоглоомоо өвөртөлж унтах, шөнийн үлгэр сонсох гэх мэт.
- Хүүхдүүдийн өөрсдийнх нь хийдэг дор хаяж хоёр зүйлийг зуруулаад зурагных нь хажууд тэрхүү зүйлийг нь бичүүл.



Усаар байлдсан нь

Уншихын өмнө

- Гарчгийг уншиж, хавтсан дээрх зургийг үзүүлээд, Чип хэнийг усаар шүршиж байна вэ? Та нар усаар шүршүүлж үзсэн үү? Цаг агаар ямархуу байсан бэ? гэж хүүхдүүдээс асуу.
- Хэн норсныг мэдэхийн тулд номыг гүйлгэн хар. Эцэст нь, Хэн норсон бэ? Үлгэрийн төгсгөлд аав яаж сэрсэн гэж та нар бодож байна вэ? гэж асуу.

Унших үед

- Хүүхдүүдээр үлгэрийг уншуул. Уншиж байхад нь магтаж урамшуул, шаардлагатай бол сануулан хэлж өг.

Ажиглалт

- Мэдэхгүй үгээ нүдэлж байхдаа цагаан толгойн болон хэл ярианы мэдлэгээ ашиглаж байгааг шалга.
- Зүүнээс баруун тийш түгдрэлгүй уншуул.
- Номын талаарх өгүүлэмжийг зөв хэрэглэж буйг шалга.
- Эх хоорондын уялдааг зөв хэрэглэж байгааг шалга.

Бүлгээр болон бие даан унших үйл ажиллагаа

Эхийн төвшинд ажиллах

Зорилт Зөв дарааллаар гол утга санааг тоочиж, сайн мэдэх сэдвээ бусдад ярьж өгөх.

- Хүүхдүүдээр үлгэрийг яриул. Шаардлагатай бол дараах асуултуудыг асуу.
Хүүхдүүд яагаад усанд сэлэхийг хүссэн бэ?
Аав яагаад үгүй гэж хэлсэн бэ?
Хэн Чипийг норгосон бэ?

Аав яагаад Чиппийг элдэж хөөв?
Аав юу хийсэн бэ?
Аавыг хэн норгосон бэ?

Ажиглалт

Хүүхдүүд үлгэрийг сануулж хэлүүлэлгүйгээр зөв дэс дарааллаар ярьж чадаж байна уу?

Өгүүлбэрийн төвшинд ажиллах

Зорилт Нүдлэх, мөн ухаанаа сорихын тулд бичсэн эхийг таамаглах.

Та самбар дээр дараах хэсэгчилсэн өгүүлбэрийг бичих хэрэгтэй. Түүний хажуугаар дутуу үгийг тусад нь бичээрэй.

Хүүхдүүд хүсэв. (сэлэхийг)

Киппер усаар дүүргэв. (түүнийг)

Тэд байлдав. (усаар)

Аав нэг ус авав. (хувин)

Чипп аав уруу ус (цацлаа)

- Хүүхдүүдээр өгүүлбэрийг уншуулж, сүүлийн үгийг хаана тавихад зөв өгүүлбэр болж байгааг ухааруул. Хэрэв шаардлагатай бол тэднийг ном хэрэглэхийг нь зөвшөөр.

Ажиглалт

Хэрхэн ухаж ойлгохыг өөрсдөө ухаарч байна уу? эсвэл өгүүлбэр ухааруулж байна уу? Номноос тусламж авах шаардлага байна уу? гэдгээ хүүхдүүд бие даан шийдэж чадаж байна уу?

Үгийн төвшинд ажиллах

Зорилт Үгсийн онцлог шинж болон энгийн үсэглэлийг мэдэх Жишээ нь: дүрс, урт гэх мэт.

Танд хөх улаан харандаа болон «Чип Бифийг ус уруу түлхэв» гэсэн бичигтэй цаас хэрэг болно.

- Хүүхдүүдээр хамгийн богино үгийг хөх харандаагаар, хамгийн урт үгийг улаан харандаагаар дугуйлуул.

- Номноос өнгөрсөн цагт буй үйл үгнүүдийг олуулж бичүүл.

Ажиглалт

Хүүхдүүд үгнүүдээс өнгөрсөн цагт буй үгнүүдийг ялгаж байна уу?

Ярих болон сонсох үйл ажиллагаа

Зорилт Гол утга санаан дээр төвлөрөх, холбогдох тодорхойлолтуудыг багтаах, ээлжээр ярих, үзэл бодлоо илэрхийлэх.

Танд «Флоппиг угаасан нь», «Усаар байлдсан нь» зэрэг номнууд, өвөл зуны хувцасны каталог, халуун өдөр, хүйтэн өдөр, чийглэг өдөр гэж дээр нь бичсэн гутлын гурван хайрцаг хэрэг болно.

- «Флоппиг угаасан нь», «Усаар байлдсан нь» зэрэг номонд гарч буй хүүхдүүдийн өмссөн хувцсыг хооронд нь харьцуул.
- Хүүхдүүдэд каталогийг үзүүлж улирал улиралд тохирсон хувцасны зургийг хайчлан авахуул.
- Хүүхдүүдээр яагаад энэ хувцас энэ улиралд тохиромжтой юм бэ гэдгийг тайлбарлуул.

Амьдрал, хичээлийн уялдаа

- ▶ Ертөнцийн талаарх ойлголт мэдлэг: Харж буй амьд бие, юмс үзэгдэл, үйл явдлын онцлог шинжийг таньж ойлгох.

Бичих үйл ажиллагаа

Зорилт Зурганд хаяг тайлбар хийх.

Танд Биф юмуу Чипийн дүрс бүхий хуулбар зураг хэрэг болно.

- Хүүхдүүдээр энэ өдөр ямар өдөр болохыг шийдвэрлүүл. Хүүхдүүдээр зохиолын баатарт хувцас өмсгөж, зуруулаад, хувцасны нэрийг бичүүл. Номын хуудсан дээрх цаг агаарын байдлыг зуруул. Тэгээд хүүхдүүд зурагныхаа доор энэ өдөр халуун, хүйтэн, чийглэг өдөр байна гэж бичнэ.



Кипперийн бөмбөлөг

Уншихын өмнө

- Гарчгийг уншуулж хавтсан дээрх зургийг үзүүл. Хүүхдүүдээс Киппер юу хийж байна вэ? Түүний худалдаж авч байгаа бөмбөлөг ямар өнгөтэй вэ? гэж асуу.
- Номыг эргүүлэн үзэж Киппер хэдэн бөмбөлөг худалдаж авсныг нь харуул. Тэд ямар өнгөтэй байсныг асуу.

Унших үед

- Хүүхдүүдээр үлгэрийг чангаар уншуул. Уншиж байхад нь тэднийг магтаж урамшуул, шаардлагатай бол сануулан хэлж өг.
- Хүүхдүүдийг уран уншихад нь, ялангуяа үгийг тод хэлэхэд нь урамшуул.

Ажиглалт

- Мэдэхгүй үгээ нүдлэхэд нь цагаан толгойн болон хэл ярианы мэдлэгээ ашиглах.
- Зүүнээс баруун тийш түгдрэлгүй унших.
- Номын өгүүлэмжийг зөв хэрэглэх.
- Эх хоорондын уялдааг зөв хэрэглэж байгааг шалгах.

Бүлгээр болон бие даан унших үйл ажиллагаа

Эхийн төвшинд ажиллах

Зорилт Үлгэрийн өрнөж, төгсч байгаа арга бүтцийг ухаарах.

Асуулт: Эхний улаан бөмбөлөг яасан бэ?

Аав яагаад хоёр дахь улаан бөмбөлөгний хойноос гүйсэн бэ?

Аав ямар алдаа гаргав. Яагаад та нар түүнийг алдаа хийсэн гэж бодож байна вэ?

Аав алдаагаа ухаараад яасан гэж бодож байна вэ?

Хоёр дахь улаан бөмбөлгийг хэн алдсан гэж бодож байна вэ? Та нар надад номон дахь түлхүүр үгийг үзүүлж чадах уу?

Ажиглалт

Хүүхдүүд аавын эндүүрлийг тайлбарлаж чадаж байна уу?

Өгүүлбэрийн төвшинд ажиллах

Зорилт Ойлгож ухаанаа шалгахын тулд бичсэн эхийг таамаглах. Танд дараах өгүүлбэрийн хуулбарууд хэрэг болно.

Киппер шинэ жорлон худалдаж авсан.

Тэд супермаркет уруу явсан.

Аав бөмбөлөг үрүү очив.

Аав түүнийг хөөлөө.

Бөмбөлөг аавын хойноос гүйлээ.

- Хүүхдүүдээр ойлгож байгаа өгүүлбэрийнхээ өмнө «+», ойлгохгүй байгаа өгүүлбэрийн өмнө «-» тэмдэг тавиул.

Ажиглалт

Ойлголтоо шалгахын тулд хүүхдүүд дахин дахин уншиж байна уу?

Үгийн төвшинд ажиллах

Зорилт Шинээр мэдэж авсан бүтээвэр, үгнүүдийг үсэгчлэн тогтоох.

Та самбар дээр дараах өгүүлбэрийг бичих хэрэгтэй. «Бөмбөлөг пан хийж хагарав».

- Хүүхдүүдээр өгүүлбэр дэх Б үсгээр эхэлсэн үгийг олуул. Энэхүү үсэг ямар авиаг илэрхийлж байгааг асуу.
- Өгүүлбэрт орж болох Б үсгээр эхэлсэн өөр үгнүүдийг нэмж хэлүүл. Жишээ нь: Баахан бөөрөнхий бөмбөлөг пан хийж хагарлаа.

Ажиглалт

Хүүхдүүд эхний авиаг тогтоож, түүнийг бичсэн үсэгтэй холбож чадаж байна уу?

Ярих болон сонсох үйл ажиллагаа

Зорилт Үйл явдлын орчин, зохиолын дүр, сэтгэлийн хөдлөл зэргээр дамжуулж хэл болон үйл явдлыг илэрхийлэх.
Танд дараах өгүүлбэрүүд хэрэг болно.

Киппер бөмбөлөг худалдаж авсан.
Авсан бөмбөлөг нь пан хийж хагарсан.
Аав бөмбөлгийг доош нь тавив.
Аав бөмбөлгийн хойноос гүйв.

- Бүлгийн хүүхэд бүрээр нэг өгүүлбэрийг сонгуулж уншуул.
Тэгээд өгүүлбэрийн үйл ядлыг биеэр дүрслэн үзүүлэхийг хүс.
- Бусад хүүхдүүд зохиолын баатарт юу тохиолдож байгааг тааж, үлгэрийн холбогдох хуудаснаас олох болно.

Бичих үйл ажиллагаа

Зорилт Янз бүрийн аргаар харилцахдаа бичих үйл ажиллагааг хэрэглэх.

- Супермаркетаас ямар зүйлийг худалдан авч болох тухай ярилцаад самбар дээр жагсаан бич.
- Хүүхдүүдээр дэлгүүрийн барааны жагсаалт бичүүлж, худалдан авахыг хүсч байгаа зүйлийнх нь зургийг зуруул.



Кипперийн төрсөн өдөр

Уншихын өмнө

- Гарчгийг уншуулж хавтсан дээрх зургийг үзүүлээд, Киппер юу хийж байна вэ? Чи түүнийг үдэшлэг хийнэ гэж бодож байна уу? гэж асуу.
- Номыг эргүүлэн үзэж Кипперийн төрсөн өдрөөр юу тохиолдсоныг хар.

Унших үед

Хүүхдүүдээр үлгэрийг уншуул. Тэднийг уншиж байхад нь магтаж урамшуул, шаардлагатай үед нь сануулан хэлж өг.

Ажиглалт

- Танил бус үгнүүдийг уншихад туслах зураг болон сэдвийн талаарх мэдлэгээ ашиглахад нь урамшуул.
- Зүүнээс баруун тийш түгдрэлгүй уншиж эхлэхийг нь шалга.
- Номын өгүүлэмжийг зөв хэрэглэх
- Эх хоорондын уялдааг зөв хэрэглэж байгааг шалгах.
- Мэдэхгүй үгээ нүдлэхдээ хам үгийн мэдлэгээ ашиглах.

Бүлгээр болон бие даан унших үйл ажиллагаа

Эхийн төвшинд ажиллах

Зорилт

Номын өгүүлэмжийг зөв хэрэглэж ойлгох.
Үлгэрийн эхэнд юу тохиолдсон бэ?
Киппер юу хүссэн бэ?
Үлгэрийн дунд хэсэгт юу тохиолдсон бэ?
Үлгэрийн төгсгөлд юу тохиолдсон бэ?
Яагаад Кипперийн үдэшлэг хүүхдүүдэд таалагдсан бэ?

Ажиглалт

Хүүхдүүд номын эхлэл болон төгсгөлийн хэсгийг зөв ярьж чадаж байна уу?

Өгүүлбэрийн төвшинд ажиллах

Зорилт Танил эхийг дахин уншихдаа үгнүүдийг урьдаас тааварлаж, өгүүлбэрийн хэлзүйн ойлголтыг хэрэглэх.

Та самбар дээр дараах үгнүүдийг бичих хэрэгтэй. «нэгэн, хийсэн, үдэшлэг, Кипер, бялуу, хүссэн, тавьсан, Биф дээш, бөмбөлөг, ээж»

- Эдгээр үгнүүдийг ашиглаж тэдний бичиж чадах олон өгүүлбэрүүдийг бичүүлэх.

Ажиглалт

Хүүхдүүд өгүүлбэр зохиох үгээ хайж байхдаа өгүүлбэрийн бүтэц, хэлзүйн мэдлэгээ ашиглаж байна уу?

Үгийн төвшинд ажиллах

Зорилт «Т» үсгийг жишээ болгон унших. Танд том зарлалын хуудас хэрэг болно.

- 6-р хуудсан дээрх аав хачиртай талх авч байгаа зургийг хүүхдүүдэд харуул.
- Хачиртай талх гэдэг үгийг самбар дээр бичээд «Т» үсгийн талаар ярилц. Хүүхдүүд «Т» үсэг орсон идэх юмны нэрийг олж чадаж байна уу? Жишээ нь: тараг, тоор жимс, төмс, торт ... гэх мэт.
- Хүүхдүүдийг бодож байх хооронд та зарлалын хуудсан дээр «Т» үсэг орсон үг нэмж бичээд харуул.

Ажиглалт

Хүүхдүүд зөв дуудлагатай үгнүүдийг санаж байна уу?

Ярих болон сонсох үйл ажиллагаа

Зорилт Салаа утгатай үгийг сонгож, ямар утгатай болохыг нь ойлгох, холбогдох тодорхойлолтыг гаргах, сонсогчдын хэрэгцээг тооцоолох.

- Үдэшлэгийн ямар тоглоомыг та нар тоглох дуртай вэ? Жишээ нь: «Боодол дамжуулах», «Илжигний сүүл хатгах», «Эрдэнийн ангууч» гэх мэт.

- Хүүхдүүдээр нэгэн тоглоом сонгуулаад хамт тоглогчдоо түүнийг хэрхэн тоглохыг тайлбарлуул.

Бичих үйл ажиллагаа

Зорилт Нэрийн эхний үсгээ томоор бичих, харилцааны янз бүрийн аргуудад бичих үйл ажиллагааг хэрэглэх. Жишээ нь: Ил захидал, урилга гэх мэт.

Танд төрсөн өдрийн урилга, хэд хэдэн өнгийн цаас, будаг хэрэг болно.

- Хүүхдүүдэд урилгыг үзүүлж үгийг нь уншуул.
- Хүүхэд бүрээр Кипперийг төрсөн өдөртөө ирүүлэх урилга бичүүл.
- Материалуудаа ашиглан хүүхдүүдээр урилгыг нь чимэглүүл.

Амьдрал, хичээлийн уялдаа

- ◀▶ Бүтээлч хөгжил: Зургийн болон зохион бүтээх уран сэтгэмжээ ашиглах.



Оксфордын уншлагын мод цуврал, шатлал 2-ын үлгэрүүд нь шатлал 1 үлгэрийн цувралд гарсан танил орчин, дүрүүдийг голлон харуулдаг.

Үлгэрүүд нь аажмаар хувиргасан үгсийн санг хэрэглэж байгаа боловч унших амжилтыг дээшлүүлэх урьдчилан тааж болохуйц өгүүлбэрийн бүтэцтэй юм.

Гарчиг бүрт эдгээр багшийн тэмдэглэлүүд нь:

- Уншихын өмнө ба унших үед зориулсан санал зөвлөгөө өгдөг.
- Бүлгээр болон бие дааж номыг уншихад эх өгүүлбэр, үгийн төвшинд ажиллах үйл ажиллагаагаар хангадаг.
- Бичих үйл ажиллагааг шинэ санаагаар тэтгэдэг.
- Бодит амьдралтай уялдуулахад анхаардаг.

Эдгээр нь:

- Харилцан хамаарал бүхий бүх хэрэглэсэн үгийн сангийн хүснэгт
- Энэ түвшин дэх Оксфордын уншлагын мод цувралын бусад материал зэргийг багтаасан юм.

Гэрийн карт нь мөн хэрэгтэй юм. Энэ нь гэртээ хүүхдүүдтэйгээ энэхүү номыг уншдаг эцэг эхчүүдэд нөхөрсөг санамж зөвлөгөө өгч тоглох тоглоомоор хангадаг.



Хэвлэн нийтлэлийг
Интерпресс ХХК



Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлж буй «Хөдөөгийн боловсролыг дэмжих (READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв. Худалдахыг хориглоно.